

ОЮУНЛАГ ХҮМҮҮН МОНГОЛЫН БАЯЛАГ 2015-2016

ЗАЛУУСЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

*Залуусын хөгжлийн
хөтөлбөрт хамрагдахыг
хүссэн залуус өргөдлийн
материалыг бүрэн гүйцэд
бүрдүүлэн, заасан хугацаанд
багтаан доорх хаягаар
ирүүлнэ.*

Боловсролын зөвлөгөө, мэдээллийн
төв, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Оюутны гудамж,
МКМ-24 байр, 1-р давхар
Утас: 319016, 331880-3769

Анхан шатны шалгаруулалтад тэнцсэн сурагчдыг
ярилцлагад урина.
Хугацаанаас хоцорсон болон дутуу бүрдүүлсэн
материалыг хүлээж авахгүй.
Ирүүлсэн материалыг буцаан олгохгүй.



ОЮУНЛАГ
ХҮМҮҮН
МОНГОЛЫН
БАЯЛАГ
2015-2016



ЗАЛУУСЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

“Оюу толгой” ХХК нь Монгол Улсын Засгийн Газартай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ болон Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамтай 2010 онд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд Монголын шилдэг оюутан залуусыг дэмжин гадаадын болон дотоодын их, дээд сургуульд суралцах тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Монголын хүүхэд залуусыг ирээдүйд чадварлаг мэргэжилтэн, манлайлагч болоход нь дэмжлэг үзүүлэх, тус компаниас хэрэгжүүлдэг тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамрагдах оюутан залуусыг улам бүр чадавхижуулах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулан “Залуусын хөгжлийн хөтөлбөр”-ийг санаачлан 2013 оноос хэрэгжүүлж эхлээд байна.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Тус хөтөлбөр нь Монгол улсын ирээдүй болсон хүүхэд залуусыг дунд сургуулийн ахлах ангиас нь эхлэн их, дээд сургуульд суралцах хугацааны туршид хувь хүн талаас нь хөгжүүлж улс орны ирээдүйн манлайлагчид, чадварлаг мэргэжилтэн болоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой.

ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

Залуусын хөгжлийн хөтөлбөр нь хүүхэд, залуусыг ирээдүйд чадварлаг мэргэжилтэн, манлайлагч болоход шаардагдах хувь хүний төлөвшлийн чадамжуудыг суулгах 5 үе шат бүхий сургалтын хөтөлбөр юм.

Сургалтын үе шатууд:

- Өөрийгөө танихуй
- Багаар ажиллах чадвар
- Өргөн хүрээнд сэтгэх
- Төслийн менежмент
- Төсөл хэрэгжүүлэх үе шат.

Эдгээр сургалтууд оюутан, сурагчдын манлайлах; бүтээлч, үр дүнтэй харилцаа тогтоох; өөрийгөө хөгжүүлэх, удирдах; ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах; хамтын ажиллагаа бий болгох, багаар ажиллах; асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргах зэрэг чадваруудыг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

Сонгогдсон Ерөнхий боловсролын дунд сургуулиудын төгсөх ангийн сурагчдаас жил бүр 50 сурагчийг шалгаруулан хөтөлбөрийн эхний шатны сургалтуудад хамруулна. Тэдгээрээс шалгарсан 5 шилдэг сурагчийг их, дээд сургуульд суралцах хугацаанд нь “Оюу толгой” ХХК-иас сургалтын тэтгэлэг олгож, хөтөлбөрийн дараагийн шатны сургалтуудад үргэлжлүүлэн хамруулна.

Хөтөлбөрийн эхний 4 шатанд бүрэн хамрагдсан эдгээр 5 сурагч 5 дахь шатны сургалт буюу сурагч багшийн сургалтанд хамрагдсанаар тус хөтөлбөрийн сурагч багш болж сургалтуудыг удирдан явуулахад оролцоно.

Хөтөлбөрийн нэг шатны сургалт 3 сар үргэлжлэх бөгөөд долоо хоног бүрийн Бямба гаригт 3 цагаар хичээллэнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ШАЛГУУР

- Монгол улсын иргэн байх;
- Сонгогдсон ЕБС-ийн төгсөх ангийн сурагч байх (жагсаалтад орсон 70 сургуулийн);
- Сурлагын дүн 80 ба түүнээс дээш байх (100 онооны үнэлгээгээр);
- Нийгмийн оролцоо, манлайлах чадвар сайтай байх.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Өргөдлийн маягт (Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төвөөс авч бүрэн гүйцэд бөглөнө үү),
- Сурлагын дүнгийн албан ёсны тодорхойлолт (сургуулийн тамгатай байх),
- Зохион бичлэг (доорх 2 сэдвээс 1-ийг нь сонгож 300-аас доошгүй үгэнд багтаан бичнэ),
Сэдэв 1: “Таны өөрөөрөө хамгийн их бахархаж байсан мөч”
Сэдэв 2: “Хэрэв та багш байсан бол ямар багш болохыг хүсэх вэ?”
- Суралцах хугацаандаа гаргасан амжилт, авсан шагнал урамшууллын хуулбар.

Өргөдөл хүлээн авах хугацаа:

Дээрх материалуудыг бүрдүүлж

Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төвд 2015 оны

9-р сарын 21-ний өдрийн 17.00 цагаас өмнө авчирч өгнө үү.

